



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2015 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/153

Мөрөн

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30.1.6, Төсвийн тухай хуулийн 58.2.13, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 26.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай" Улсын онцгой комиссын 01 дүгээр албан даалгаварын хэрэгжилтэнд хяналт тавих зорилгоор аймгийн Засаг даргын 2015 оны А/97 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн аймгийн бүх сумдад ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад зориулж 11300660 төгрөгийг зарцуулсугай.

2. Аймгийн онцгой комиссын 03 дугаар хуралдаанд Онцгой байдлын газрын дарга С.Даваасүрэнгийн оруулсан мэдээлэлтэй холбогдуулан "Усны гарвалтай ослоос урьдчилан сэргийлэх тухай" аймгийн Засаг даргын 2015 оны А/107 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсгийн 2 дугаар ээлжийг батлагдсан удирдамжийн дагуу 2015.04.24-нийг хүртэл Хатгал тосгон дахь постонд ажиллуулж, шаардагдах зардалд 1385500 төгрөгийг зарцуулсугай.

3. Дээрх урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдах 12686160 /Арван хоёр сая зургаан зуун наян зургаан мянга нэг зуун жаран/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Г.Төмөрбаатар, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Г.Сувд нарт зөвшөөрсүгэй.

4. Батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, бүртгэлд тусган үр дүнг тайлагнаж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга, онцгой байдлын хурандаа С.Даваасүрэнд үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /М.Очирхуяг/-д даалгасугай.

ДАРГА

А.ЭРДЭНЭБААТАР